



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛААЛТ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ОНЫ ЭХНИЙ 4 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

УЛААНБААТАР ХОТ
2019.05.13

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ЭХНИЙ 4 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

II. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт **2,051.5** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **80.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **910.6** тэрбум төгрөг,
- Цайр **76.9** тэрбум төгрөг,
- Зэс **871.9** тэрбум төгрөг,
- Төмөр **17.1** тэрбум төгрөг,
- Жонш **16.3** тэрбум төгрөг,
- Бусад **78.8** тэрбум төгрөг,

Улсын төсөвт орсон орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **456.3** тэрбум төгрөг буюу **28.6** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **31.0 (63.1%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **306.8 (50.8%)** тэрбум төгрөг,
- Цайр **13.6 (21.5%)** тэрбум төгрөг,
- Зэс **71.1 (8.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **4.7 (38.6%)** тэрбум төгрөг,
- Жонш **4.0 (32.1%)** тэрбум төгрөг,
- Бусад **25.0 (46.5%)** тэрбум төгрөг.

2019 оны эхний 4 сарын байдлаар улсын төсөвт **981.0** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **13.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **448.2** тэрбум төгрөг,
- Цайр **33.5** тэрбум төгрөг,
- Зэс **448.0** тэрбум төгрөг,
- Төмөр **6.7** тэрбум төгрөг,
- Жонш **9.7** тэрбум төгрөг,
- Бусад **21.9** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **286.1** тэрбум төгрөг буюу **41.2** хувиар өссөн байна. Үүнд:

- Алт **1.5 (13.0%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **192.4 (75.2%)** тэрбум төгрөг,
- Зэс **96.0 (27.3%)** тэрбум төгрөг,
- Жонш **5.1 (110.0%)** тэрбум төгрөг,

Харин дараах ашигт малтмалын татвар, хураамж буурсан байна. Үүнд:

- Цайр **4.2 (11.1%)** тэрбум төгрөг,
- Төмөр **1.6 (19.4%)** тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал **3.1 (12.4%)** тэрбум төгрөг.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018		2019		Өөрчлөлт			
	IV	I-IV	IV	I-IV	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	246.7	694.8	314.1	981.0	67.4	27.3%	286.1	41.2%
Алт	5.0	11.5	4.1	13.0	-0.9	-18.8%	1.5	13.0%
Нүүрс	104.2	255.8	130.7	448.2	26.6	25.5%	192.4	75.2%
Цайр	15.7	37.7	15.4	33.5	-0.3	-1.9%	-4.2	-11.1%
Зэс	109.5	352.0	148.1	448.0	38.7	35.3%	96.0	27.3%
Төмөр	2.2	8.3	1.8	6.7	-0.4	-17.7%	-1.6	-19.4%
Жонш	1.2	4.6	5.6	9.7	4.4	362.8%	5.1	110.0%
Бусад	8.9	25.0	8.3	21.9	-0.6	-6.9%	-3.1	-12.4%

II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

II.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2019 оны эхний 4 сард **16.8** сая тн нүүрс, **473.3** мян.тн зэсийн баяжмал, **2.3** тн алт, **1.7** мян.тн молибдений баяжмал, **40.3** мян.тн хайлуур жоншны хүдэр, **4.3** мян.тн хайлуур жоншны баяжмал, **2.1** сая тн төмрийн хүдэр, **1.0** сая тн төмрийн хүдрийн баяжмал, **31.7** мян.тн цайрын баяжмал, **2.2** сая тн бар газрын тос үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс **2.0** сая тн буюу **13.7%**, зэсийн баяжмал **34.2** мян.тн буюу **7.8%**, молибдены баяжмал **1.3** тн буюу **0.1%**, төмрийн хүдэр **469.5** мян.тн буюу **29.3%**, төмрийн хүдрийн баяжмал **15.0** мян.тн буюу **1.5%**, хайлуур жоншны хүдэр **2.3** мян.тн буюу **6.0%**, цайрын баяжмал **1.7** мян.тн буюу **5.7%**-иар ихээр тус тус өссөн байна.

Харин алт **581.4** кг буюу **20.1%**, хайлуур жоншны баяжмал **18.0** мян.тн буюу **84.1%**, газрын тос **60.6** мян.бар буюу **2.7%**, катодын зэс **439.8** тн буюу **9.2%**-иар тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2018		2019		Өөрчлөлт			
			IV	I-IV	IV	I-IV	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр									
1.1	Нүүрс	мян.тн	3,840.0	14,773.4	3,906.5	16,794.1	66.5	1.7%	2,020.7	13.7%
1.2	Газрын тос	мян.бар	535.0	2,281.2	549.4	2,220.5	14.4	2.7%	-60.6	-2.7%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	112.2	439.1	118.1	473.3	5.9	5.3%	34.2	7.8%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	422.8	1,729.7	409.0	1,731.0	-13.8	-3.3%	1.3	0.1%
1.5	Алт	кг	1,017.5	2,888.3	999.3	2,306.9	-18.2	-1.8%	-581.4	-20.1%
1.6	Төмөр:									
	- Төмрийн хүдэр	мян.тн	446.9	1,601.6	827.1	2,071.1	380.2	85.1%	469.5	29.3%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	231.0	1,021.0	281.3	1,036.0	50.3	21.8%	15.0	1.5%
1.7	Хайлуур жонш:									
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	9.6	38.0	13.1	40.3	3.5	36.2%	2.3	6.0%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	8.3	21.3	2.1	3.4	-6.2	-74.8%	-18.0	-84.1%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	6.6	30.0	7.7	31.7	1.1	17.3%	1.7	5.7%
2	Боловсруулах аж үйлдвэр									
2.1	Катодын зэс, 99%	тн	1,186.0	4,767.8	1,031.9	4,328.0	-154.1	-13.0%	-439.8	-9.2%
2.2	Металл бэлдэц	тн	3,613.7	11,621.0	2,037.8	9,858.6	-1,575.8	-43.6%	-1,762.4	-15.2%
2.3	Металл цувимал	тн	3,033.0	10,793.2	1,704.1	9,261.0	-1,328.9	-43.8%	-1,532.2	-14.2%

Эх сурвалж: ҮСХ

II.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Өөрчлөлт			
	IV	I-IV	IV	I-IV	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,235.4	4,500.7	1,437.8	5,306.8	202.4	16.4%	806.2	17.9%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	887.3	3,219.5	1,039.5	3,898.2	152.2	17.2%	678.7	21.1%
Нүүрс олборлолт	347.6	1,126.4	408.6	1,692.8	61.0	17.5%	566.4	50.3%
Газрын тос олборлолт	84.5	345.0	91.6	329.6	7.1	8.4%	-15.4	-4.5%
Металлын хүдэр олборлолт	440.7	1,707.7	529.8	1,842.1	89.1	20.2%	134.5	7.9%
Бусад ашигт малтмал олборлолт	14.5	40.4	9.5	33.7	-5.0	-34.3%	-6.7	-16.5%
Боловсруулах аж үйлдвэр	255.5	882.6	295.7	971.8	40.2	15.7%	89.2	10.1%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний 4 сард **5.3** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **806.2 (17.9%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **3.9** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **678.7 (21.1%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **566.4 (50.3%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **134.5 (7.9%)** тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **73.5%**-ийг эзэлж байна.

II.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2018		2019			Өөрчлөлт			
	IV	I-IV	IV	I-IV	Гад-дал	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,465.8	5,288.4	1,833.1	6,450.6	4,785.9	367.3	25.1%	1,162.1	22.0%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,032.2	3,743.3	1,291.0	4,589.7	4,140.1	258.8	25.1%	846.5	22.6%
Нүүрс олборлолт	351.9	1,372.2	489.4	1,810.9	1,623.4	137.5	39.1%	438.6	32.0%
Газрын тос олборлолт	91.5	334.8	80.9	312.5	312.5	-10.6	-11.5%	-22.2	-6.6%
Металлын хүдэр олборлолт	576.8	1,992.2	705.2	2,410.0	2,172.9	128.5	22.3%	417.8	21.0%
Бусад ашигт малтмал олборлолт	12.1	44.1	15.4	56.4	31.3	3.3	27.7%	3.3	27.8%
Боловсруулах аж үйлдвэр	340.3	1,143.7	438.7	1,421.8	645.7	98.4	28.9%	278.1	24.3%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны эхний 4 сард **6.5** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.2 (22.0%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **4.6** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **846.5 (22.6%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **438.6 (32.0%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **417.8 (21.0%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс **4.8 (74.2%)** их наяд төгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнээс **4.1 (64.2%)** их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.

III. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр **4.3** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **570.9 (15.4%)** сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү **745.8** сая ам.доллараар эерэг гарсан байна.

III.1. ЭКСПОРТ

Экспорт **2.5** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **386.6 (18.2%)** сая ам.доллараар өссөн байна. Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын **98.6%** буюу нийт экспортын **83.2** хувийг эзлэж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-IV		2019 I-IV		Өөрчлөлт			
			Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Хувь	Үнийн дүн	Хувь
1	Чулуун нүүрс	сая тн/сая \$	10.2	789.9	11.4	961.0	1.2	12.1%	171.0	21.7%
2	Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	458.6	627.6	489.1	701.4	30.5	6.7%	73.8	11.8%
3	Боловсруулаагүй нефть	сая бар/сая \$	2.2	138.8	2.1	118.5	-0.10	-4.7%	-20.3	-14.6%
4	Төмрийн хүдэр, баяжмал	сая тн/сая \$	2.0	92.5	2.8	159.0	0.8	39.6%	66.5	71.9%
5	Хайлуур жонш	мян.тн/сая \$	113.8	36.5	151.8	55.0	38.0	33.3%	18.5	50.7%
6	Цайрын хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	41.6	75.2	54.1	78.7	12.4	29.8%	3.5	4.7%
7	Молибдений хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	1.9	14.3	1.9	16.2	-0.01	-0.6%	1.9	13.0%
8	Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	6.5	16.7	6.6	15.2	0.1	1.9%	-1.4	-8.7%
9	Цагаан тугалганы хүдэр, баяжмал	тн/сая \$	25.1	0.3	39.1	0.6	14.0	56.0%	0.3	84.2%
10	Гянтболдын хүдэр, баяжмал	тн/сая \$	81.9	1.1	90.0	0.9	8.1	9.9%	-0.2	-15.9%
11	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	кг/сая \$	3.4	144.5	4.7	195.9	1.2	35.9%	51.4	35.6%

Эх сурвалж: ГЕГ

Чулуун нүүрс экспорт 2019 оны эхний 4 сард **961.0** сая ам.долларын **11.4** сая тн-ыг экспортолсоныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр **171.0** сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд **1,226.8** мян.тн-оор тус тус их байна. **2018** оны мөн үед 1 тн нүүрсний хилийн дундаж үнэ **77.8** ам.доллар байсан бол 2019 онд **84.4** ам.доллар болж өссөн байна.

Зэсийн баяжмалын экспорт 2019 оны эхний 4 сард **489.1** мян.тн-ыг экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **30.5** мян.тн-оор их байгаа ба хилийн дундаж үнэ **1,368.6** ам.доллараас **1,434.0** ам.доллар болж **65.4** ам.доллараар өссөн байна. 2018 оны эхний 4 сард зэсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр **672.6** сая ам.доллар байсан бол тайлант сард **701.4** сая ам.доллар болсон.

Боловсруулаагүй нефтийн экспорт **2,105.9** мян.бар буюу **118.5** сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **104.3** мян.бар-аар, үнийн дүнгээр **20.3** сая ам.доллараар тус тус бага байна. 1 баррель нефтийн хилийн дундаж үнэ **62.8** ам.доллар байсан бол тайланд хугацаанд **56.3** ам.доллар болж буурсан.

Төмрийн хүдрийн экспорт **2,842.1** мян.тн буюу **159.0** сая ам.долларт хүрсэн байна. 2018 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад уг бүтээгдэхүүний экспорт **806.4** мян.тн-оор, үнийн дүн нь **66.5** сая ам.доллараар тус тус өссөн. 1 тн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ **56.0** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **10.5** ам.доллараар өссөн байна.

Цайрын баяжмалын экспорт 2019 оны эхний 4 сард **54.1** мян.тн цайрын баяжмалын 1 тн-ыг дунджаар **1,455.6** ам.доллараар экспортлосон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ **349.5** ам.доллараар буурсан. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр **78.7** сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос **3.5** сая ам.доллараар нэмэгджээ.

Хайлуур жоншны экспорт 2019 оны эхний 4 сард **55.0** сая ам.долларын **151.8** мян.тн экспортлосон нь 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **37.9** мян.тн-оор, үнийн дүнгээр **18.5** сая ам.доллараар тус тус өссөн. Хайлуур жоншны экспортын дундаж үнэ **362.2** ам.доллар болж,

өнгөрсөн оны мөн үеийнхээс **41.7** ам.доллараар өссөн байна. Жоншийг БНХАУ, ОХУ, БНСУ руу экспортлосон ба **34.9%** нь ОХУ-д, **64.4%** нь БНХАУ-д тус тус ногдож байна.

Молибдены баяжмалын экспорт үнийн дүнгээр **16.1** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **1.8** сая ам.доллараар өссөн байна. Тус бүтээгдэхүүний 1 тн-ны экспортын хилийн дундаж үнэ **7,623.0** ам.доллараас **8,663.9** ам.долларт хүрч, **1,041.0** ам.доллараар өсчээ. 2019 оны эхний 4 сард **1,864.1** тн-ыг экспортлосон нь өнгөрсөн оны мөн үеэс **11.5** тн-оор бага байна. Молибдений баяжмалын **81.4** хувийг БНХАУ-руу гаргасан байна.

III.2. ИМПОРТ

Импорт **1.8** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **184.3 (11.7%)** сая ам.доллараар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт **409.6** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс **48.1** сая ам.доллараар буюу **13.3** хувиар өслөө. Эрдэс бүтээгдэхүүний импортын **84.8%**-ийг нефтийн бүтээгдэхүүн эзлэж байна. 2019 оны эхний 4 сард **347.3** сая ам.долларын **562.8** мян.тн нефтийн бүтээгдэхүүн импортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **115.7** мян.тн-оор, үнийн дүнгээр **50.3** сая ам.доллараар тус тус өссөн. Нефтийн бүтээгдэхүүний импортын **92.4** хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний **35.7** хувийг автобензин, **64.3** хувийг дизель түлшний импорт эзлэж байна.

2019 оны эхний 4 сард **185.8** мян.тн автобензин импортлосон нь 2018 оны мөн үеийн дүнгээс **74.9** мян.тн-оор их байна. 2018 оны мөн үед 1 тн автобензины импортын дундаж үнэ **673.2** ам.доллар байсан бол 2019 онд **559.5** ам.доллар болж **16.9%**-иар буурсан байна.

Дизель түлшний импорт **334.1** мян.тн болж 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **77.7** мян.тн-оор өссөн байна. 2018 оны эхний 4 сард 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ **642.6** ам.доллар байсан бол энэ онд **620.6** ам.долларт хүрч **22.1** ам.доллар буюу **3.4%**-иар буурсан байна. Дизелийн түлшний импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **42.6** сая ам.доллараар нэмэгджээ.